



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 1/48

Хужирт сум

Үйл ажиллагааг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу хэмжээний удирдамж батлах тухай” А/482 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд томуу, томуу төст өвчлөл, амьсгалын замын цочмог хүнд халдварт ихсэж томуугийн эрсдлийн үнэлгээгээр дэгдэлтийн түвшинд байгаа тул 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуусталх хугацаанд Сургуулийн өмнөх байгууллагуудын үйл ажиллагааг түр зогсоосугай.
2. Шаардлагатай үед нэмэлт эмнэлгийн орыг төлөвлөгөөний дагуу дэлгэх, хүний нөөц, эмнэлгийн тусlamжийн бэлэн байдлыг хангахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв)-д үүрэг болгосугай.
3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ирцийн мэдээнд тандалт хийж хяналт тавих, сурагчдын амны хаалт зүүх, гарын ариун цэвэр сахих, анги танхимын агааржуулалт, ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.
4. Коронавируст халдварт, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд амны хаалт зүүх, хүн хоорондын зайд барих талаар заавар зөвлөмж, сурталчилгааг сумын вэб сайт, бусад олон нийтийн сүлжээгээр тогтмол сурталчилан ажиллахыг Эрүүл мэнд төв (Э.Оюунпүрэв)-д үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМОНХ



000001005